

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Мэдээллийн товхимол

2025 оны II улирал



ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2-т улсын хэмжээнд гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл; аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд орон нутгийн зөвлөлийг байгуулж, гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн болон салбар дундын хамтын ажиллагаа, иргэдийн оролцоог хангах, бодлогын зөвлөмж гаргах чиг үүргийг хэрэгжүүлэхээр зохицуулсан.

Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 63 дугаар тогтоолоор Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийг анхлан байгуулж, 2020 оны 189 дүгээр тогтоолоор тус зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан.


Улмаар Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 21 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралтаар “Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл”-ийн бүрэлдэхүүн дарга, орлогч дарга, нарийн бичиг, 21 гишүүнтэйгээр дахин шинэчлэгдэн батлагдсан юм.

Үндэсний зөвлөлийн 2024 оны хуралдааныг 12 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулж, хуралдааны шийдвэр болгон нийт 10 бүлэг 32 арга хэмжээ бүхий зөвлөмжийг батлан гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн гишүүд болон орон нутгийн зөвлөлд хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ОРОН НУТГИЙН ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн 2025 оны төлөвлөгөөнд дүн шинжилгээг хийхдээ нийт тусгагдсан арга хэмжээг “бүтцийн болон бүтцийн бус” арга хэмжээ, мөн Гамшгийн эрсдэлийн бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн зорилтын хүрээнд 4 тэргүүлэх чиглэлтэй уялдсан байдал, мөн гамшгийн төрөл тус бүрээр арга хэмжээг төлөвлөсөн байдалд гамшгийн өртөх байдал (объектын гал түймрийн хувьд тохиолдлын тоогоор)-д үндэслэн хийв. Дүн шинжилгээгээр нийт ГЭБОНЗ-ийн төлөвлөгөөнд 817 арга хэмжээ тусгагдсанаас бүтцийн 53, бүтцийн бус 764 арга хэмжээ тусгагдсан байна.

Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн тэргүүлэх чиглэлийн хүрээнд уялдуулан тусгасан байдал:




Тэргүүлэх чиглэл 1. Гамшгийн эрсдэлийг бууруулах бүх нийтийн мэдлэг ойлголтыг гүнзгийрүүлэх, мэдлэг олгох;

Тэргүүлэх чиглэл 2. Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны удирдлагын засаглалыг бэхжүүлэх;


Тэргүүлэх чиглэл 3. Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;

Тэргүүлэх чиглэл 4. Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах, гамшгийн дараах сэргээн босгох, нөхөн сэргээх, шинээр барьж байгуулах үйл ажиллагааг урт хугацаанд төлөвлөн хэрэгжүүлэх

21 аймгийн ГЭБОНЗ-ийн 2025 оны төлөвлөгөөнд гамшгийн төрөл тус бүрээр тусгасан арга хэмжээний тоо



Нийслэл, 9 дүүргийн ГЭБОНЗ-ийн 2025 оны төлөвлөгөөнд гамшгийн төрөл тус бүрээр тусгасан арга хэмжээний тоо



СЕНДАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ БАРИМТ БИЧГИЙН ТЭРГҮҮЛЭХ
ЧИГЛЭЛ, ЗОРИЛТТОЙ УЯЛДУУЛАН ТУСГАСАН АРГА ХЭМЖЭЭ
(АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮҮРГЭЭР)

No	ГЭБОНЗ	Сендайн дунд хугацааны стратегид тусгасан арга хэмжээтэй уялдсан байдал							Бусад
		Ойлголтыг нэмэгдүүлэх, мэдлэг олгох		Засаглал		Хөрөнгө оруулалт	Бэлэн байдлыг хангах, сэргээн босгох		
		Иргэд олон нийтэд мэдлэг олгох	Гамшгийн эрсдэлийн үнэлгээ	Эрх зүйн орчныг боловсронгуй болгох	Түншлэл хамтын ажиллагаа	Дэвшилтэт техник, технологи	Бэлэн байдлыг дээшлүүлэх, хүч хэрэгслийг нэмэгдүүлэх	Сэргээн босгох	
1	Нийслэл	15	3	1		3	12	3	1
2	Баянгол	16	6	2			5	2	1
3	Баянзүрх	28	6				8	1	2
4	Чингэлтэй	7	3	1	3	2	1	2	
5	Сүхбаатар	15	3	1	1	3	4	1	2
6	Сонгинохайрхан	23	2		2	2	10	3	7
7	Хан-Уул	13	4				1		2
8	Багануур	14	4				5	3	2
9	Багахангай	15	4					1	2
10	Налайх	17	6		1	2	2	3	8
11	Архангай	2	2	1		2	2		
12	Баянхонгор	5	5	1	1	2	2		
13	Баян-Өлгий	5	2	2	1	3	6	1	
14	Булган	5	2	2		3	6	1	6
15	Говь-Алтай	3	4	2	2	2	5	2	2
16	Говьсүмбэр	5	2	1	2	5	6	1	2
17	Дархан-Уул	11	6		1		1		1
18	Дорноговь	3	2			4	3		3
19	Дорнод	12	5	2	1	3	2	1	1
20	Дундговь	18	1	1	2	4	3		5
21	Завхан	5	2	3			4	1	5
22	Орхон	8	1	1	2		1		1
23	Өвөрхангай	6	1			1	1	1	6
24	Өмнөговь	8	5			2		1	
25	Сүхбаатар	7	3	2	2	3	6		8
26	Төв	8	3			1	3		2
27	Увс	11	4				6		3
28	Ховд	4	4	1		3	4		2
29	Хөвсгөл	5	1	3		4	3	1	2
30	Хэнтий	5	3	1		1	7		1
Нийт		299	99	28	21	57	123	29	77
		398		49		57	152		

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ДЭЛХИЙН ПЛАТФОРМЫН VIII ХУРАЛДААН

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Гамшгийн эрсдэлийг бууруулах газраас Швейцарын Холбооны Улсын Засгийн газартай хамтран 2025 оны 06 дугаар сарын 02-06-ны өдрүүдэд Женев хотноо Сендайн хүрээ хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай “Гамшгийн эрсдэлийг бууруулах дэлхийн платформын VIII чуулган”-ыг зохион байгуулсан.



Хуралдааны нэгдсэн уриа:

“ГАМШГИЙГ ДАВАН ТУУЛАХ
ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХИЙН
ЧУХЛЫГ ӨДӨР БҮР САНАЖ,
ӨНӨӨДРӨӨС ТОДОРХОЙ
ҮЙЛДЭЛ ХИЙ”

Одоогийн болон ирээдүйд учирч болзошгүй эрсдэл, тодорхойгүй нөхцөл байдлыг хурдацтай өөрчлөгдөж буй уур амьсгалд тохируулан удирдах нь

Нэг ч хүнийг орхигдуулахгүй байхад жендерийн тэгш байдал, хүртээмж, оролцоог эрхэмлэх

Хамтын тогтвортой ирээдүйн төлөө шаардлагатай арга хэмжээг эрчимжүүлэх

Тус чуулганд нийт 163 улс орны 3000 орчим төлөөлөгч оролцсон. Чуулганы үндсэн үйл ажиллагаа нь Сайд нарын дугуй ширээний хуралдаан, Өндөр түвшний хуралдаан, Сэдэвчилсэн хуралдаан, Олон талт хуралдаан зэрэг үндсэн хэлбэрээр зохион байгуулагдсан бол чуулганы үеэр Гамшгийн эрсдэлийг бууруулах инновацын үзэсгэлэн, “Гамшгийн зарлан мэдээллийн форум”, “Гамшгаас сэргээн босгох арга хэмжээний талуудын уулзалт”, “Дэлхийн эрсдэлийн шагнал гардуулах ёслол”, “Сасакава шагнал гардуулах ёслол” зэрэг арга хэмжээ зэрэгцээ зохион байгуулагдсан (нийт албан ёсны хуралдаан 36, албан бус салбар хуралдаан-39). Чуулганд Онцгой байдлын ерөнхий газрын дарга бөгөөд Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн ажлын албаны дарга, хошууч генерал Г.Ариунбуян тэргүүтэй Монгол Улсын Онцгой байдлын байгууллагын төлөөлөл, Нийслэл, Баянгол, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүрэг, Баянхонгор, Дархан-Уул аймгийн онцгой байдлын газар, хэлтэс, Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн дарга, гишүүд оролцсон.



МОНГОЛ УЛСААС “ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ДЭЛХИЙН ПЛАТФОРМЫН VIII ЧУУЛГАН”-Ы ҮЙЛ АЖИЛЛАГААНД ИЛТГЭЛ ТАНИЛЦУУЛСАН ТАЛААР

- 1. “Сургуулиудын аюулгүй байдал” цогц сэдэвт сайд нарын дугуй ширээний хуралдаан: “Гамшгийн эрсдэлийг бууруулах боловсролыг нэг ч хүүхдийг орхигдуулахгүй олгох нь”



“Хүүхэд бүрийн гамшиг, уур амьсгалын эрсдэлээс хамгаалагдах, аюулгүй суралцах эрхийг хангах тухай” энэхүү өндөр түвшний хуралдаанд ОБЕГ-ын дарга, хошууч генерал Г.Ариунбуян оролцож үг хэлсэн. Монгол Улсад хийгдэж байгаа сургуулиудын гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ, үнэлгээний үр дүнд үндэслэн гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байгаа туршлагаас хуваалцсан. Мөн “Өсвөрийн аврагч” бүлгэм, гамшгийн зарлан мэдээллийн дуут дохиогоор ажиллах өдөр, бие даалтын долоо хоногийн хүрээнд зохион байгуулсан гамшгийн эрсдэлийг бууруулах мэдлэг олгох санаачилга, арга хэмжээ болон бусад агуулгыг хөндөж, оролцогчдыг гамшгийн эрсдэлийг бууруулах боловсролыг нэг ч хүүхдэд орхигдуулахгүй олгоход анхаарал хандуулахыг уриалсан.

- 2. “Ирээдүй хойч үед чиглэсэн гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг эрчимжүүлэх хүрээнд стратеги алсын хараа, шинэ санаа, инновацыг ашиглах нь” олон талт хуралдаан



Энэхүү хуралдаанд ОБЕГ-ын Эрсдэлийн удирдлагын газрын дарга, Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн Нарийн бичгийн дарга, хурандаа Д.Баасансүрэн оролцож мэдээлэл хийсэн бөгөөд тус хуралдаан нь Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн хэрэгжилтийг сайжруулахад хиймэл дагуул, нисгэгчгүй нисэх төхөөрөмж, орчны мэдрэгчийг ашиглан үер, гал түймэр зэрэг аюулыг хянах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, хор уршгийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх, болзошгүй эрсдэл болон хохирлын үнэлгээ хийх; газарзүйн мэдээллийн системийг ашиглан хот төлөвлөлт, нөөцийн оновчтой хуваарилалт, аврах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах зэргээр шийдвэр гаргах явцад ашиглах; гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэх чиглэлээр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг бодлогын түвшинд дэмжихийг уриалсан.

- **3. “Хүчтэй салхи, шороон шуурганы эрсдэлийг бууруулах асуудлыг хөгжлийн бодлого, стратегитай уялдуулах нь” сэдэвт салбар хуралдаан**



Уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан Монгол Улс төдийгүй дэлхийн хэмжээнд уур амьсгалын гаралтай гамшиг, аюулт үзэгдлийн тохиолдол, давтамж, эрчим нэмэгдсээр байна. Энэхүү салбар хуралдаан нь хүчтэй салхи, шороон шуурганы менежментийг үндэсний болон орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах стратегид нэгтгэн уялдуулах, салбар хоорондын хамтын ажиллагааг дэмжих, гамшгийн бэлэн байдал, хариу арга хэмжээг сайжруулахын тулд засаглалын механизмыг бэхжүүлэх зэрэг олон чухал сэдвийг хөндсөн. Хуралдаанд Онцгой байдлын байгууллагаас илтгэл танилцуулсан.

- **4. Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн хүрээ баримт бичиг”-ийн хэрэгжилтийг Ази, Номхон далайн орнуудын бүс нутагт түргэсгэх чиглэлээр хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцсан үндэсний төлөөлөгчдийн уулзалт**

Хуралдаанд гамшгийн шууд болон шууд бус хохирлыг мэдээллийн сан, эрсдэлийг бууруулахад хэрхэн хөрөнгө оруулалтыг нэмэх асуудлаар санал шийдэл солилцов. “Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн зөвлөл, эрсдэлийг бууруулах засаглал” сэдвээр хуралдаанд Онцгой байдлын байгууллагаас илтгэл танилцуулсан.




ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ СЕНДАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ БАРИМТ БИЧГИЙН ДУНД ХУГАЦААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ (ДЭЛХИЙ ДАХИНАА)


ЗОРИЛТ




Гамшгийн улмаас амь насаа алдсан хүний тоог бууруулах тухай нэгдүгээр зорилтын хүрээнд дэлхийн дундаж буурсан ч Ази, Номхон далайн бүс нутагт өссөн. (2005-2014 онд 100.000 хүнд оногдох нас баралтын тоо 1.77 байсан бол 2012-2021 онд 0.87 болж буурсан)



Гамшгийн улмаас бэртэж гэмтсэн хүний тоог бууруулах тухай хоёрдугаар зорилтын хүрээнд дэлхийн дундаж буурсан ч гамшигт өртсөн хүн амын тоо 2004-2015 оны суурь түвшинтэй харьцуулахад нэг дахин өссөн. (гамшигт өртсөн хүн амын тоо 2015-2021 онд жилд 150,214,597 байх ба 2005-2014 оны суурь түвшинтэй харьцуулахад 100,000 хүн тутамд 1147 байснаас 2012-2021 онд 2066 болж өссөн)




Гамшгийн улмаас учирсан эдийн засгийн шууд хохирлын хэмжээг бууруулах тухай зорилтын хүрээнд сүүлийн арван жилд дэлхийн эдийн засагт гамшгийн улмаас учирсан шууд хохирол буураагүй буюу жилд дунджаар 330 тэрбум ам.долларт хүрч өссөн (шууд бус хохирлыг тооцоогүй).




Гамшгийн улмаас нэн чухал дэд бүтэц, суурь үйлчилгээнд үзүүлэх нөлөөллийг бууруулах тухай зорилтын хүрээнд 2004-2015 оны суурь түвшинтэй харьцуулахад гамшигт өртсөн нэгж дэд бүтцийн тоо 1.2 дахин өссөн.



Гамшгийн эрсдэлийг бууруулах стратегийг үндэсний болон орон нутгийн түвшинд баталж хэрэгжүүлсэн улс орны тоог нэмэгдүүлэх тухай зорилтын хүрээнд нийт 122 улс орон үндэсний түвшинд, 99 улс орон орон нутгийн түвшинд эрсдэлийг бууруулах стратегийг баталсан буюу хэрэгжилт 70 хувь байна.



Гамшгийн эрсдэлийг бууруулахад олон улсын тусламж, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх тухай зорилтын хүрээнд өнгөрсөн хугацаанд нийт 44 улс орон аль нэг байдлаар гадаадын тусламж, хөрөнгө оруулалтад хамрагдсан байгаа нь гамшгийн өмнөх болон дараах хөрөнгө оруулалтын үр өгөөж 1:15 ам доллар байгаа энэ цаг үед хангалтгүй байна.



Гамшгийн эрт зарлан мэдээлэл тогтолцоог бүрдүүлэх тухай зорилтын хүрээнд нийт 120 улс орон гамшгийн өмнөх сэрэмжлүүлэг, гамшгийн үед зарлан мэдээлэх тогтолцоог бүрдүүлснээс 90 улс орон олон гамшгийн төрлөөр зарлан мэдээллийг хүргэх нөхцөл боломжийг бүрдүүлсэн нь 2015 оны суурь түвшинтэй харьцуулахад дээрх тогтолцоог бүрдүүлсэн улс орны тоо 2 дахин нэмэгдсэн байна.

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ СЕНДАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ БАРИМТ БИЧГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГААС БАТЛАГДСАН ХӨТӨЛБӨР ЗОРИЛТУУД

Бодлого, хөтөлбөр	Хугацаа
“Сургуулиудын цогц аюулгүй байдлыг хангах хөтөлбөр”	2022-2030
“Гамшгийн зарлан мэдээллийг хүн бүрд санаачилга”	2022-2027
“Аюулгүй гамшигт тэсвэртэй хот хөтөлбөр”	-2030
“Гамшгийн эрсдэлийг бууруулах Ази, Номхон далайн бүсийн төлөвлөгөө”	2024-2026

“ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ДЭЛХИЙН VIII ЧУУЛГАН”-ААС ГАРГАСАН ХАМТАРСАН МЭДЭГДЭЛ

Чуулганы оролцогчид “Гамшгийн эрсдэлийг бууруулах Женевийн уриалга” баримт бичгийг санал нэгдэн баталж, хэрэгжүүлэх үүрэг амлалтыг авсан. Дараах нэн чухал арга хэмжээг дараагийн 5 жилийн хугацаанд анхаарч ажиллахаар баримт бичигт тусгасан байна. Үүнд:

- 1. Гамшгийн эрсдэлийг сайн ойлгоход чиглэсэн нарийвчилсан дата мэдээлэл:** Гамшгийн эрсдэлийн мэдээллийг цуглуулах, шинжлэх, түүнийг ашиглах нь гамшгийг тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх үндэс суурь болно. Иймд улс, орнууд гамшгийн түүхэн мэдээллийг цуглуулж, хуваалцах; гамшгийн нөлөөллийг нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, орлогын түвшин зэргээр ангилан бүртгэх, хянах; урьдчилан таамаглах шинжилгээ хийх шаардлагатай. Мөн Сендайн мониторингийн системийн хэрэглээ, ашиглалтыг улс орнууд бүрэн ашиглах шаардлагатай.
- 2. Дэвшилтэт технологийг ашиглан ахиц дэвшлийг хурдасгах:** Бүх улс орон, орон нутгийн иргэд шинээр хөгжиж буй технологийг, тухайлбал хиймэл оюун ухааныг ашиглан гамшгийн эрсдэлийг бууруулах үйл явцыг эрчимжүүлэх боломжтой. Иймд хөгжиж буй улс орнууд болон бүх улсын алслагдсан иргэдэд технологийг хялбар, тэгш хүртээмжтэй хүргэх, ашиглахад онцгой анхаарах.
- 3. Эрсдэлийн засаглал, хамтын ажиллагааг уялдуулан зохицуулахад дэмжлэг үзүүлэх:** Эрсдэлийн уламжлалт ойлголт, байгууллага, салбар хоорондын хаалттай байдлыг өөрчлөх, төлөвлөлтийг салбар дундын уялдаатай, шинэлэг арга барилаар хамтран ажиллах боломжийг бий болгох шаардлагатай байна. Энэ хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, гамшгийн эрсдэлийг бууруулах, нийгэм, байгаль орчны хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхэд цогц эрсдэлийн менежментийн хандлагыг хэрэгжүүлэх. Мөн хил дамнасан болон шинээр үүсэж буй эрсдэлүүд (мөнх цаст мөсөн голын үер, далайн түвшин нэмэгдэх, элсэн болон шороон шуурга, эрс халалт зэрэг)-ийг үр дүнтэй



бууруулахын тулд олон улсын болон бүс нутгийн хамтын ажиллагааг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргын “Хэт халалтын эсрэг уриалгатай” уялдуулан нэмэгдүүлэх.

4. **Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хөрөнгө оруулах:** Дотоодын төсөв, уур амьсгалын санхүүжилт, хувийн хэвшилтэй хамтарсан шинэлэг санхүүгийн механизмуудыг ашиглах зэрэг байдлаар гамшгийн эрсдэлийг бууруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх. Мөн гамшгийн эрсдэл өндөр, гамшигт ихээр өртөж буй улс орнуудад чиглэсэн олон улсын санхүүжилт, техникийн туслалцааг нэмэгдүүлэх шаардлагатай. Гамшгийн эрсдэлийн менежментийн чадавхыг Сантьягогийн сүлжээ (Santiago Network)-ний хүрээнд бэхжүүлэх боломжтой.
5. **Бүх төрлийн хөрөнгө оруулалтад эрсдэлийн мэдээллийг ашиглах:** Гамшгийн эрсдэлийг сайтар тодорхойлоогүй тохиолдолд хөгжлийн аливаа төсөламжилтгүй болно. Иймд олон нийтийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг гамшгийн эрсдэлийг сайтар тодорхойлсон чиглэлд хандуулах. Тухайлбал, боловсролын салбарын тэсвэртэй байдлыг бэхжүүлэхэд хийсэн хөрөнгө оруулалт нь олон талын эерэг нөлөөтэй. Сургуулийн цогц аюулгүй байдал хөтөлбөр (Comprehensive School Safety Framework)-ийг хэрэгжүүлснээр хүүхэд, залуусыг гамшгийн аюулаас хамгаалах боломжтой болно.
6. **Эрт зарлан мэдээлэх системийг өргөжүүлэх:** Гамшгийн улмаас амь насаа алдсан хүний тоог бууруулахад олон аюулын эрт зарлан мэдээлэх систем маш чухал үүрэгтэй ч дэлхийн хүн амын талаас илүү хувь нь зарлан мэдээллийг хүлээн авах боломж бүрэн бүрдээгүй байна. Иймд хүн бүрд эрт зарлан мэдээллийг хүртээмжтэй хүргэх хүрээнд олон улсын дэмжлэгийг нэмэгдүүлэх, үндэсний хэмжээнд зарлан мэдээллийг бодитой нэмэгдүүлэхэд анхаарах, мөн урьдчилан сэргийлэх арга хэмжээ, нийгмийн хамгааллын тогтолцоо, тэгш бус байдлыг бууруулахад чиглэсэн хөрөнгө оруулалт нь гамшгийн хохирлыг бууруулах, сэргээн босгох арга хэмжээг хурдасгахад чухал хувь нэмэр оруулна.
7. **Нэг ч хүнийг орхигдуулахгүй байх:** Улс орон, оролцогч талууд “Сендайн Хүйсийн тэгш байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө (Sendai Gender Action Plan)”, “Хүүхэд, залуусын дэлхий нийтийн уриалга (Global Children and Youth Call to Action)”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах зөвлөмжүүд” зэрэг зорилтуудын хэрэгжилтийг хангахад анхаарах.
8. **Сайжруулан сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхэд бэлэн байдлыг хангах:** Гамшгийн дараах сайжруулан сэргээн босгох, бэлэн байдлыг хангахад улс орнууд илүү оновчтой төлөвлөх шаардлагатай. Энэ нь хүн бүрийн оролцоог хангасан, зөвхөн дэд бүтцийг бус, иргэдийн амьжиргаа, нийгмийн тогтвортой байдлыг давхар бэхжүүлэх чухал ач холбогдолтой.

ГАМШИГ, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСЛЫН ДАТА МЭДЭЭЛЭЛ



2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Монгол Улсын хэмжээнд тохиолдсон гамшиг, аюулт үзэгдэл, ослын статистик

Тохиолдлын тоо



2567

Тохиолдлын тоо

93

Амь насаа алдсан хүн

104

Бэртэж гэмтсэн хүн

7859

Хорогдсон мал

26,7 тэрбум

Учирсан хохирол

“МОНГОЛ ХҮН БА ЭРСДЭЛИЙН БОЛОВСРОЛ”

Гамшгийн эрсдэлийг бууруулах бүх нийтийн мэдлэг, ойлголт, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл”-ийн 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаас гарсан зөвлөмжийн 4.2-т “Монгол хүн ба эрсдэлийн боловсрол” аяныг улсын хэмжээнд зохион байгуулахаар тусгасан.


ЭНЭ ХҮРЭЭНД 2025
ОНД “МОНГОЛ ХҮН
БА ЭРСДЭЛИЙН
БОЛОВСРОЛ” АЯНЫГ
УЛСЫН ХЭМЖЭЭНД
ӨРНҮҮЛНЭ.

Аяны хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээнээс:

- Гамшгийн эрсдэлийн асуудлаар 2025 оны 10 дугаар сарын дөрөвдүгээр долоо хоногт улсын хэмжээнд телевизийн шууд нэвтрүүлэг зохион байгуулж, холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулах,
- Бүх шатны боловсрол, эрүүл мэндийн байгууллагад гамшгийн үед ашиглагдах зам гарцыг чөлөөлөх хөдөлгөөн өрнүүлэх,
- Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах уламжлалт арга, ухааныг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр богино хэмжээний судалгааны ажил хийж, үр дүнг иргэд олон нийтэд хүргэх,
- Аймаг, нийслэлийн хэмжээнд удирдамж боловсруулж сургуулийн насны хүүхдүүдэд “Гамшгийн эрсдэл” сэдвээр гар зургийн уралдаан зохион байгуулах,
- Аймаг, орон нутгийн хэмжээнд “Эрсдэлгүй гудамж”-ийг бий болгох зорилгоор нэгээс доошгүй гудамж, талбайг сонгож тохижуулах.

МОНГОЛ
ХҮН
БА
ЭРСДЭЛИЙН
БОЛОВСРОЛ





ӨӨРИЙНХӨӨ БОЛОН БАЙГУУЛЛАГЫНХАА АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ АНХАН ШАТНЫ ТҮВШИНД ШАЛГАЖ ХЭВШЭЭРЭЙ

“Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах, аж ахуйн нэгж, байгууллага, хуулийн этгээд, иргэдийн гамшгаас хамгаалах мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, аюулгүй амьдрах хэв маягийг төлөвшүүлэх зорилгоор Монгол Улсын Шадар сайдын тушаалаар “Олон нийтийн оролцоонд тулгуурлан гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний удирдамж”-ийг батлуулсан. Энэ хүрээнд Онцгой байдлын байгууллагаас төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хуулийн этгээд, иргэд өөрсдийн аюулгүй байдлыг үнэлж, эрсдэлээ тооцоолох хялбаршуулсан асуумж бүхий хяналтын хуудсыг боловсруулж, цахим хэлбэрт шилжүүлэн Онцгой байдлын ерөнхий газрын <http://quiz.belenbai.mn/> сайтад байршуулсан.

Хяналтын хуудасны төрөл:




- төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага гамшгийн бэлэн байдлаа шалгах хяналтын хуудас,
- өрхийн гамшгийн бэлэн байдлыг шалгах “Аюулгүй өрх” хяналтын хуудас,
- иргэний гамшгаас хамгаалах мэдлэг, ойлголтыг шалгах асуумж



www.belenbai.mn

ГАМШГИЙН БЭЛЭН БАЙДЛАА ШАЛГАХ ХЯНАЛТЫН ХУУДАС

Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, хуулийн этгээд, иргэн бүр тогтмол хугацаанд байгууллагынхаа болоод өөрийнхөө аюулгүй байдлын үнэлгээг доорх хялбаршуулсан хяналтын хуудаснуудын тусламжтайгаар хийж хэвших шаардлагатай. Ингэснээр аливаа гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, учирч болзошгүй эрсдэлийг бууруулахад нэн тэргүүнд шаардлагатай зүйлс, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар анхан шатны мэдлэгтэй болно. Энэ нь өөрийн байгууллага болоод гэр бүл, өөрийгөө тохиолдож болзошгүй гамшиг осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд туйлын чухал юм.



Гамшгийн эрсдэлийн нөхцөл байдал

Монгол Улсад зонхилон тохиолддог гамшгийн 10 төрлөөр үндэсний болон нийслэл, 9 дүүрэг, 21 аймгийн хэмжээнд гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийж аюул, өртөх байдал, эмзэг байдлын зураглалыг хүн ам, аж ахуйн нэгж, байгууллага, өрх айл, улсын чанартай авто зам, төмөр зам, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, эрүүл мэнд болон боловсролын байгууллага, цахилгаан дулааны шугам сүлжээ, дэд станцууд, ургацын талбай, бэлчээрийн талбайн зэрэг 26 элементээр 500 гаруй зураглал боловсруулсан.


Үнэлгээнийүрдүн,зураглалыгболовсруулахдаа Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 68 дугаар тушаалаар батлагдсан “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх заавар”-ын дагуу 5 түвшинд тодорхойлсон.

Энэ удаагийн дугаарт эрүүл мэндийн байгууллагын өртөх байдлыг онцоллоо.

ГАМШГИЙН ТӨРӨЛ:

- Ган
- Зуд
- Газар хөдлөлт
- Хүчтэй салхи
- Үер
- Аянга
- Цасан шуурга
- Ой хээрийн түймэр
- Зоонозын өвчин
- Шороон шуурга

Эрүүл мэндийн байгууллагын олон аюулд өртөх байдлын зураглал



Таних тэмдэг
Барилгын өртөх байдал

Эмнэлэг

▲

 Маш их

▲

 Их

▲

 Дунд

▲

 Бага

▲

 Маш бага

Эмийн сан

◆

 Маш их

◆

 Их

◆

 Дунд

◆

 Бага

◆

 Маш бага

Эрүүл мэндийн төв

+

 Маш их

+

 Их

+

 Дунд

+

 Бага

+

 Маш бага

Клиник, сувилал

■

 Маш их

■

 Их

■

 Дунд

■

 Бага


■

 Маш бага

Эрүүл мэндийн байгууллага	Өртөх байдлын түвшин				
	Маш бага	Бага	Дунд	Их	Маш их
Эрүүл мэндийн төв		9	406	416	47
Эмнэлэг	21	161	702	459	127
Клиник, сувилал	14	82	237	129	47
Эмийн сан		8	36	27	2
Нийт	35	260	1381	1031	223
Эзлэх хувь	1,2%	8,9%	47,1%	35,2%	7,6%

Эрүүл мэндийн байгууллагын олон аюулд өртөх байдал /Бүсийн хэмжээнд/


Эрсдэлийн түвшин	Эрсдэлийн зэрэглэл, өнгө
Маш их	5
Их	4
Дунд	3
Маш бага	2
Бага	1



Үерт өртөх байдал бүхий эрүүл мэндийн байгууллагын тоо, бүсийн хэмжээнд эзлэх хувь

Бүс	Аймаг	Маш бага	Бага	Дунд	Их	Маш их
Улаанбаатар			3	1028	570	
Зүүн бүс	Дорнод	2	45	11		
	Сүхбаатар	3	37			
	Хэнтий		50	26		
	Нийт	5	132	37	0	0
Хангайн бүс	Архангай		8	63	13	
	Баянхонгор	12	14	45		
	Өвөрхангай	6	24	52		
	Нийт	18	46	160	13	0
Баруун бүс	Баян-Өлгий		6	21	40	
	Говь-Алтай	9	21	3		
	Завхан	4	28	46		
	Увс	4	8	48		
	Ховд	11	38	10		
	Нийт	28	101	128	40	0
Хойд бүс	Булган		19	29	3	
	Орхон			71		
	Хөвсгөл			85	14	
	Нийт	0	19	185	17	0
Төвийн бүс	Дархан-Уул		2	71		
	Сэлэнгэ		8	49	3	
	Төв		26	56	2	
	Нийт	0	36	176	5	0
Говийн бүс	Говьсүмбэр		15			
	Дорноговь	16	45			
	Дундговь	6	35	2		
	Өмнөговь	8	56			
	Нийт	30	151	2	0	0
Нийт		81	488	1716	645	0

Эрүүл мэндийн байгууллагын үерт өртөх байдлын зураглал /сумаар/



ОЙ, ХЭЭРИЙН ТҮЙМРИЙН ЭРСДЭЛ, НӨХЦӨЛ БАЙДАЛ


2004-2024 он
(нийт дүнгээр)



2025 оны эхний хагас
жилд

Улсын хэмжээнд 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 12 аймгийн 65 сум, нийслэлийн 3 дүүрэгт нийт 144 удаагийн ой, хээрийн гал түймэр бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **49.3** хувиар өссөн үзүүлэлт юм.

ОЙ, ХЭЭРИЙН ГАЛ ТҮЙМРИЙН АЮУЛЫН ЗЭРЭГТЭЙ 2025 ОНД ТОХИОЛДСОН ТҮЙМРИЙН ГОЛОМТЫН БАЙРШЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ (2025.06.10-ны өдрийн байдлаар)



2025.01.01-6.10-ны байдлаар	Нийт	Ой, хээрийн гал түймрийн аюулын зэрэг			
		Бага	Дунд	Их	Маш их
Ой, хээрийн гал түймрийн тохиолдлын тоо	105	4	11	59	31
Нийт ой, хээрийн гал түймрийн тохиолдолд эзлэх хувь	100%	4%	10%	56%	30%

	Нийт	Түймрийн аюулын зэрэг			
		V & IV	III	II	I
Түймрийн аюулын мужийн талбай (км ²)	830,360	215,360	209,930	276,500	128,570
Нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь	52.6	13.6	13.3	17.5	8.1

ОБЕГ-ын Эрдэсзүйн удирдлагын газрын Зарлан мэдээлэл, мэдээллийн сангийн хэлтэст боловсруулав.

№	Аймгийн нэр	Сумын нэр	Тохиолдлын тоо	Нийт
1	Архангай	Хайрхан	1	2
2		Цэнхэр	1	
3		Баян-Агт	1	
4		Бугат	3	
5		Дашинчилэн	1	
6	Булган	Орхон	1	11
7		Сэлэнгэ	3	
8		Төвий	1	
9		Хангал	1	
10	Дархан-Уул	Хонгор	2	2
11	Дорноговь	Иххэт	1	1
12		Баянтүмэн	2	
13		Баян-Уул	1	
14		Булган	3	
15		Дашбалбар	2	
16	Дорнод	Халхгол	4	18
17		Хэрлэн	1	
18		Цагаан-Овоо	1	
19		Чойбалсан	3	
20		Чулуунхороот	1	
21	Дундговь	Баянхонгор	1	2
22		Луус	1	
23	Завхан	Баянтас	1	1
24		Асгат	3	
25		Дарьганга	1	
26		Мөнххаан	1	
27	Сүхбаатар	Сүхбаатар	2	13
28		Уулбаян	1	
29		Халзан	1	
30		Эрдэнэцагаан	4	
31		Баянгол	2	
32		Зүүнбүрэн	1	
33		Мандал	3	
34		Сайхан	1	
35	Сэлэнгэ	Сант	1	21
36		Түшиг	2	
37		Хүдэр	5	
38		Ерөө	5	
39		Цагааннуур	1	
40		Жаргалант	1	
41		Мөнгөнморьт	3	
42	Төв	Өндөрширээт	1	9
43		Сэрэлэн	1	
44		Батсүмбэр	1	
45		Эрдэнэ	2	
46	Увс	Сагил	1	1
47		Баянзүрх	1	
48	Улаанбаатар хот	Хан-Уул	1	3
49		Чингэлтэй	1	
50		Цагаан-Уул	1	
51	Хөвсгөл	Эрдэнэбулган	2	4
52		Баттөр	1	
53		Батширээт	3	
54		Баян-Адаг	1	
55		Баянмөнх	1	
56		Баян-Овоо	3	
57		Баянхонгор	1	
58		Дадал	2	
59	Хэнтий	Дархан	1	18
60		Дэлгэрхаан	1	
61		Норовлин	2	
62		Хэрлэн	1	
63		Цэнхэрмандал	1	
64	Нийт		106	106


ҮЕРИЙН ЭРСДЭЛ, НӨХЦӨЛ БАЙДАЛ

Үерийн эрсдэлийн ерөнхий үнэлгээгээр 21 аймгаас Орхон, Говьсүмбэр, Сүхбаатар их эрсдэлтэй буюу улбар шар түвшинд, Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан, Говь-Алтай, Баянхонгор, Хөвсгөл, Булган, Төв, Өвөрхангай, Өмнөговь, Дундговь, Дархан, Сэлэнгэ, Дорноговь, Хэнтий аймгууд дунд эрсдэлтэй, Дорнод, Архангай аймгууд бага эрсдэлтэй байна.

Мөн 21 аймгийн 330 сумын хэмжээнд маш их эрсдэлтэй 19 сум, их эрсдэлтэй 30 сум, дунд эрсдэлтэй 159 сум, бага эрсдэлтэй 94 сум, маш бага эрсдэлтэй 28 сум байна.

Харин үерийн эрсдэлтэй “маш их буюу их” түвшинд байгаа 49 сумын 137.740 өрх айл үерт өртөх эрсдэлтэйг тооцооллоо.

Улсын хэмжээнд сүүлийн 10 жилийн хугацаанд ус, цаг уурын гаралтай аюулт үзэгдлийн 1220 тохиолдол бүртгэгдсэний 35.5 хувийг аадар бороо, үер эзэлж байгаа бөгөөд үүний улмаас 54 хүн амь насаа алдаж (14 хүүхэд), 4241 гэр усанд автаж, 51,131 толгой мал хорогдсон бол 2025 оны эхний 6 сарын байдлаар усны ослоор 23 хүн амь насаа алдсан байна.



ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ОРОН НУТГИЙН ЗӨВЛӨЛӨӨС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНЭЭС

Сүхбаатар дүүрэг:

ГЭБОНЗ-өөс гамшгаас хамгаалах багаж, тоног төхөөрөмжийн бэлтгэл, бэлэн байдал, хүчин чадлыг нэмэгдүүлэх хүрээнд 1,2 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн (бохир ус соруулах насос-3 ширхэг, цахилгаан үүсгүүр-1 ширхэг, гэрэлт цамхаг-1 ширхэг).



Сонгинохайрхан дүүрэг:

Дүүргийн ГЭБОНЗ-өөс Онцгой байдлын хэлтэст туулах чадвар өндөр “TANK-300”, техник хэрэгсэл зөөвөрлөх зориулалттай давхар кабинтай “Bongo”, шуурхай ажиллагааны зориулалттай 8 ба 12 хүний суудалтай “Voxy”, “Starex” автомашинууд болон үер усны үед бэлэн байдлыг хангахад зориулагдсан 250м үерийн угсардаг далан зэргийг гардуулан өгсөн.

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас 2025 оныг “Орц, Гарц чөлөөлөх жил” болгон зарласан ба энэ хүрээнд гэнэтийн аюул, гамшгийн эрсдэл тохиолдох үед бэлэн байдлыг хангах чиглэлээр олон ажлуудыг зохион байгуулсан байна.



Багахангай дүүрэг:

Барилга зураг төслийн “Хот айл” ХХК-тай гэрээ байгуулж, дүүргийн 1 дүгээр хорооны орон сууцны 2 дугаар байранд “Газархөдлөлтийн тэсвэржилтийн үнэлгээ” хийлгэн, паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлтийг гаргуулсан. Тус арга хэмжээнд 8,000,000 төгрөгийг зарцуулсан бөгөөд 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдөр тайланг хүлээн авсан.



Гамшгийн нөхцөл байдлыг үнэлж, тодорхойлох зорилгоор 10,000,000 төгрөгийн үнэ бүхий Нисгэгчгүй нисдэг төхөөрөмж (Дрон)-ийг худалдан авч, бэлэн байдлыг ханган ажилласан.



ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ БОЛОН ОРОН НУТГИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭН ЭРХ

1. Монгол Улсын холбогдох хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт гамшгийн эрсдэлийг бууруулах стратегийн зорилт болон шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тусгуулах талаар бодлогын зөвлөмж өгөх;
2. гамшгийн дараах сэргээн босгох арга хэмжээг оновчтой хэрэгжүүлэх, улс орны тогтвортой хөгжлийн бодлого, зорилтод уялдуулах бодлогын зөвлөмж гаргах;
3. гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагаа, иргэдийн оролцоог хангах;
4. гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд шинжлэх ухаан, техник, технологийн шинэ ололт, инновацыг нэвтрүүлэх талаар чиглэл өгөх;
5. Орон нутгийн зөвлөлийг бодлого, зөвлөмжөөр хангах (Гамшгаас хамгаалах тухай хууль)

1. ГЭБОНЗ нь ГХТХ-ийн 27.2-т заасан бүрэн эрхээс гадна энэ журмыг өөрийн эрх мэдлийн хүрээнд хэрэгжүүлнэ.
2. Орон нутгийн хэмжээнд гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөлтийг хөгжлийн бодлого, төлөвлөлтөд тусгах, холбогдох зардлыг шийдвэрлэж хэрэгжилтийг хангах.
3. Үндэсний зөвлөлийн шийдвэрийн биелэлт, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа, түүний үр дүн, авч хэрэгжүүлсэн арга хэмжээг Үндэсний зөвлөлд улирал тутам тайлагнана. (Засгийн газрын 2020 оны 189 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн ажиллах журам”)

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА

Холбоо барих:
Утас: 51-263585, 51-263579
Имэйл: undesniizuvlul@nema.gov.mn